

## **ДАЛБААНЫ ЭЗЭН УЛСЫН ХЯНАН ШАЛГАГЧ МЭРГЭЖИЛТНИЙ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

### **Ерөнхий шаардлага:**

1. Хувийн эрүүл мэндэд сайтар анхаарч томилолтын хугацаанд үзлэг шалгалтын өмнө сайтар амарч байх.
2. Ажил үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, болзошгүй аюул, ослын үед анхан шатны тусламж үзүүлэх мэдлэгтэй байх.
3. Хөлөг онгоцон дээрх аюулгүй ажиллагааны дуут дохио, анхааруулах санамж, тэмдэг, тэмдэглэгээг эзэмшсэн байх.
4. Томилолтоор ажиллах хугацаа, нислэгийн хуваарь, маршрутыг гаргахдаа амралтын цагийг бодож гаргах.

### **Үзлэг шалгалт явуулах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа:**

1. Хөлөг онгоц дээр гарахын өмнө өөрийн аюулгүй байдлыг сайтар хангаж ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх.
2. Боомтын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөх.
3. Үзлэг шалгалт явуулахын өмнө эзэмшигч компанийн төлөөлөл, сюрвейртэй холбогдож хөлөг онгоцны зогсоолын байршил, ачаа ачих, буулгах цагийн хуваарь, график зэрэг нэмэлт мэдээллүүдийг урьдчилан мэдсэн байх шаардлагатай.
4. Үзлэг шалгалт явуулахдаа ачигч кран, техник төхөөрөмжийн өмнө зогсохгүй байх, боомтын ажилчдын ачаа бараа буулгах, ачих нөхцөлд хүндрэл учруулахгүй байх.
5. Боомтын бүсээр явахдаа явган зорчигчдод тусгайлан зориулсан тэмдэг тэмдэглэгээтэй замаар явах, хэрэв тийм зам байхгүй нөхцөлд хүнд даацын машин механизмд харагдахуйц газраар явж өөрийн аюулгүй байдлаа сайтар хангаж ажиллах.
6. Дуу чимээ ихтэй хөдөлгүүрийн өрөө, тоног төхөөрөмж, хөдөлгүүрт үзлэг явуулахдаа дуу чимээ тусгаарлах зориулалтын чихэвч хэрэглэнэ.
7. Хөлөг онгоцны давхар хоорондын шатаар өгсөж уруудахдаа шатны бариулаас 2 гараараа барьж хий гишгэх, халтирч унахаас сэргийлэн аюулгүй байдлаа сайтар хангаж ажиллана.
8. Хөлөг онгоц дээрх мөн боомтын эрэг дагуух гэрэлтүүлэггүй болон агааржуулалт хийгдээгүй өрөөнд орохыг хориглоно.
9. Боомт болон эргээс бага оврын завиар хөлөг онгоцон дээр гарахдаа хөлөг онгоцны шатны бэхлэгээг сайтар шалгасны дараа авирах.
- 10. Хөлөг онгоцны ахмад болон түүнийг орлож буй туслахад үзлэг, шалгалт явуулах газраа урьдчилж мэдэгдэж харгалзах хүнтэй явж шалгалтаа хийнэ.

### **Нэмэлт зааварчилгаа:**

## **АЧААГ ГАРААР ӨРГӨХ, ЗӨӨХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

- Баглаа боодолтой болон бусад ширхэгийн ачааг зөөвөрлөхдөө гараа шархлуулахгүйн тулд бүгдийг нь урьдчилан сайтар шалгаж үзэх хэрэгтэй, / төмөр баглааны үзүүр, хадаасанд гараа ураг, зүсэх эрсдэлтэйг анхаарах./ Хайрцгийг буюу боодлыг хураасан газраас авахдаа хажууд нь байгаа ачаа унахгүй, тогтвортой байдалд байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Ачааг зөвхөн хураалтын дээд талаас авбал зохино. Ачааны хүнд, хөнгөнийг сайн тохируулах. Хэт хүнд, овор ихтэй ачаа өргөхгүй байх.

- Ачаандаа үнэлгээ хийх-Өргөж явах хооронд ачааны зарим хэсэг хөдөлж болох эсэх /бөөрөнхий зүйлс, лонх, хуйлсан зүйл гэх мэт/.
- Хөлөө зөв тавих. /нэг хөлөө ачааны ард, нөгөө хөлөө явах гэж байгаа зүг рүүгээ харуулж ачааныхаа хажууд тавь./
- Ачаанд хүрэх гэж бүсэлхийгээрээ бүү тонгой. Өвдгөө нугал. /дараа нь доошоо тонгойж ачаандаа хүр./
- Ачаагаа эсрэг хоёр талаас нь чанга барь.
- Ачааг бүсэлхийгээрээ тонгойсон үедээ бүү өргө. Ачаа өргөж байхдаа огцом хөдөлж, эргэж болохгүй.
- Яаж өргөхөө төлөвлө.
- Замд тээглэх зүйлсийг холдуул.
- Өөрөө өргөж чадахааргүй бол бусдаас тусламж ав.
- Хүнд, овор хэмжээ ихтэй барааг зөөхдөө өргөх механизм ашигла.
- Баллон шил савыг зөөвөрлөхдөө тусгай тавиур дээр тавьж зөөвөрлөх ба ийм ачааг зөөх, өндөрт гаргахдаа бие дээрээ зөөвөрлөхийг хориглоно.
- Бургидаг ачааг зөвхөн тоос үл нэвтрэх нүдний шил ба амьсгалуур хэрэглэсэн нөхцөлд гараар ачиж буулгаж болно.
- Өдөр бүр ажлын тусгай хувцасны тоосыг гөвнө. Амьсгалуурын шүүлтүүрийг бохирдвол солих ёстой.
- Хлорт шохойг ачиж буулгахдаа шүүлтүүртэй буюу амьсгалууртай хорт хийн багийг заавал өмсөнө
- +40° С ба түүнээс дээш халуун байгаа үед цементийг гараар ачиж болохгүй.
- Хүний гараар өргөх ачааны дээд хэмжээ нь стандартад заасны дагуу эмэгтэй хүн - 20 кг, эрэгтэй хүн — 36 кг байна.

### **ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАХ ЗААВАРЧИЛГАА**

Техникийн засвар, үйлчилгээ хийдэг байранд галын аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөнө.Үүнд:

- Шатах тослох материал арчсан алчуур, даавууг ил задгай хаяхгүй, цахилгаан, ил гал, нарны шууд тусгалаас хол байлгах,
- Хаалга, гал унтраах хэрэгсэл байгаа газрын орчимд хог, хаягдал овоолох, тээврийн хэрэгслийг байрлуулах, амархан гал авалцах материалыг ил саванд хадгалахыг хориглоно.
- Хэрэв зөөврийн цахилгаан гэрэлтүүлэг хэрэглэх шаардлагатай бол гэрэлтүүлэгт хамгаалалтын тор байгаа эсэх болон залгуур тусгаарлах резинэн гуурс бүрэн, бүтэн эсэхийг шалгана.
- Бензиний сав, бензиний хоолойд бензиний үлдэгдэл байгаа эсэхийг шалгах.
- Агрегатаас тос, усыг зөвхөн тусгай зориулалтын газарт юүлнэ. Шалан дээр гоожсон тос буюу шингэнийг нэн даруй хуурай элс, үртэс цацан, тусгай газарт цуглуулна.
- Гагнуурын ажил гүйцэтгэхдээ бензин болон бензин зөөвөрлөхөд ашиглаж байсан савыг ойрхон байлгахыг хориглоно.
- Гал түймэр гарсан тохиолдолд гал унтраах байгууллагад яаралтай мэдэгдэн, унтраах арга хэмжээ авна.
- Гал түймэр гарсан тохиолдолд хүмүүсийг аюулгүй газарт гаргах арга хэмжээ авах.
- Гал түймэр гарсан тохиолдолд цахилгаан хэрэгслийг цахилгааны тэжээлээс салгах.